



БАЯНХОНГОР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2017.11
2017.11



ГАРЧИГ

Аргачлалын тайлбар	3-4
Орон нутгийн төсвийн орлого, зарлага	5
Ажиллагсад, ажилгүйчүүд, ажлын байр	5-6
Мөнгө, банк.....	6-7
Үнэ.....	7
Аж үйлдвэр	7-8
Хөдөө аж ахуй	8-9
Нийгмийн даатгал, нийгмийн халамж.....	10
Эрүүл мэнд.....	10-11
Гэмт хэрэг.....	11-12
Аялал жуулчлал.....	12-13

АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

- **Хөдөлмөр:** Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн хүмүүс орсон болно.
- **Эрүүл мэнд, Гэмт хэрэг:** Уг салбарын мэдээнүүдийг холбогдох газар, хэлтсүүд нь нэгтгэн гаргаж ирүүлдэг.
 - **1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
 - **1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
- **Гэмт хэрэг:** Аймгийн цагдаагийн газраас захиргааны статистик мэдээгээр нэгтгэн гаргадаг.
- **Эрүүгийн хуульд** эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдон гэмт хэргийн нэр төрөл урьдынхаас нилээд өөрчлөгдсөн.

 - Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүйгээс алах хэргийг нэгтгэн оруулсан.
 - Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулсан.
 - Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдыг эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг хамруулсан.
 - Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгт гал түймрийн хэргийг хамруулсан.
 - Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт танхайн гэмт хэргийг оруулсан.
 - 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог оны эхний 18 ба түүнээс дээш насны хүн амд харьцуулан тооцно.
- **Хэрэглээний үнийн индекс / ХҮИ / гэдэг нь** хэрэглэгчдийн худалдаж авсан бараа үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

- Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, 2008 оны 1 дүгээр сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2010 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.
- **Мөнгө, банк:** Монгол банк арилжааны банкуудаас мэдээг авч нэгтгэн, банкуудын үндсэн материалын хамт ирүүлдэг.
- **Төрийн санхүү:** Төсвийн орлого, зарлагын мэдээг Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна. Аймгийн төсвийн орлого нь аймаг, сумын төсвийн орлогоос бүрдэнэ. Аймгийн төсвийн мэдээг Санхүү, төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.
- **Хөдөө аж ахуй:** Мал төллөлт, төл бойжилт, мал хорогдлын мэдээг багийн Засаг дарга нар өрхөөс цуглуулж, сумын тамгын газарт нэгтгэн ирүүлдэг.
- **Аж үйлдвэр:** Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна. Үндсэн нэгжүүд мэдээг ирүүлдэг.

Нийт бүтээгдэхүүний өсөлтийг тооцохдоо: гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2010 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно.

Борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд оны үнээр үнэлж, худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.




ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

2017 оны эхний 11 сарын байдлаар аймгийн төсвийн орлогын дүн 9689,6 сая төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 1546,9 сая төгрөгөөр буюу 15,9 хувиар өссөн байна. 2017 оны эхний 11 сарын байдлаар нийт орлогын болон татварын орлогын төлөвлөгөөг Галуут, Эрдэнэцогт, Гурванбулаг, Баяновоо, Өлзийт, Бөмбөгөр, Баянбулаг, Заг, Жинст, Богд, Баянлиг, Баянцагаан, Баацагаан, Бууцагаан сумууд биелүүлсэн байна.

Орлогын төлөвлөгөөний биелэлтийг төрөл дээр нь авч үзвэл: Агаарын бохирдол /авто/ 14,6 сая төгрөг, ЦХТА орлого 109,8 сая төгрөг, АТӨЯХ-н татвар 41,8 сая төгрөг, ҮХЭХ-ийн татвар 25,2 сая төгрөг, Газрын төлбөр 31,2 сая төгрөг, Бууны татвар 7,1 сая төгрөг, Түгээмэл тархацтай АМАТ 2,5 сая төгрөгөөр тус тус тасарч, бусад нэр төрөлд биелэлээ.

Нийт орлогод ААНБ-н орлогын албан татвар 2,8 хувь, нэмүү өртгийн албан татвар 4,2 хувь, ЦХТА орлого 45,2 хувь, авто тээвэр өөрөө авагч хэрэгслийн татвар 4,0 хувь, бусад төлбөр хураамж 43,8 хувийг эзэлж байна.



АЖИЛГҮЙДЭЛ, АЖЛЫН БАЙР, АЖИЛЛАГСАД

2017 оны эхний 11 сарын байдлаар аймгийн бүртгэлтэй ажилгүй иргэд 998 болж өмнөх оны мөн үеэс 40.8 хувиар буурчээ. Нийт ажилгүй иргэдийн 53.4 хувь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 15-44 насныхан 79.8 хувь, 45 дээш насныхан 20.1 хувийг эзлэж байна. Харин боловсролын түвшнээр харвал бүрэн дунд хүртэл боловсролтой 59.5 хувь, тусгай мэргэжлийн болон техникийн боловсролтой 10.7 хувь, дээд, магистар, доктор боловсролтой 28.7 хувийг тус тус эзлэж байна.


Эхний 11 сарын байдлаар бүртгэлтэй ажилгүйчүүдээс 729 хүн ажилд зуучлагдан орсон өмнөх оны мөн үеэс 2.5 хувиар буурчээ. Ажил орсон иргэдийн 81.1 хувь нь 15-44 насныхан байжээ.

Шинэ ажлын байранд нийт 368 иргэн ажиллаж байгаа бөгөөд үүний 41.0 хувь буюу 151 эмэгтэйчүүд байна. Шинэ ажлын байранд ажиллаж байгаа иргэдийг эдийн засгийн салбараар харвал Хөдөө аж ахуйн салбарт 81, Боловсруулах үйлдвэрийн салбарт 90, Уул

уурхай, олборлолт 22, Худалдааны салбарт 30, бусад салбаруудад 145 хүнд шинэ ажлын байр гаргаж ажиллаж байна.

Эхний 11 сарын байдлаар нийт 978 ажлын байрны захиалга ирсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 13.7 хувиар өссөн байна. Ажлын байрны захиалгыг эдийн засгийн салбараар үзвэл Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгалд 137, боловсруулах үйлдвэрлэлд 123, Хөдөө аж ахуйн салбарт 203, бусад салбаруудад 1-84 ажлын байрны захиалга иржээ.

Бүртгэлтэй ажилгүй иргэд




МӨНГӨ ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖ

Монгол банкны аймаг дахь салбараас ирүүлсэн мэдээгээр 2017 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар арилжааны банкуудаар 1981,5 сая төгрөг эргэлдэж байна.

Оны эхний 11 сарын байдлаар нийт зээлийн өрийн үлдэгдэл 140523,5 сая төгрөг байгаагийн 442,7 сая.төг нь хэвийн зээл, 1916,6 сая.төг нь анхаарал хандуулах зээл /хугацаа хэтэрсэн/, 2795,3 сая төгрөгийн чанаргүй зээл байна.

Эхний 11 сарын байдлаар иргэдийн хадгаламж 74890,1 сая.төг болжээ. Үүний 17112,9 сая.төг нь хугацаагүй хадгаламж, 57568,2 сая төг нь хугацаатай хадгаламж байна.


Аймгийн банкны салбарын нийт ашиг өссөн дүнгээр 11711,2 сая.төг болжээ.





ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2017 оны 11 дүгээр сард бараа үйлчилгээний үнэ тариф 2016 оны 12 сарынхаас 8,7 хувиар, өнгөрсөн оны мөн үеийнхээс 9,6 хувиар өсч, өмнөх сарынхаас 0,6 хувиар өссөн байна. Хүнсний бараа ундаа усны бүлгийн дүн 2017 оны 11 дүгээр сард өмнөх сарынхтай харьцуулахад 1.5 хувиар, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлгийн дүн 0,1 хувиар буурч, хувцас, бөс бараа, гуталын бүлгийн дүн 1,1 хувиар, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн дүн 0,3 хувиар, гэр ахуйн тавилга, барааны бүлгийн дүн 0,5 хувиар, бусад бараа үйлчилгээний бүлгийн дүн 1,9 хувиар өсч, орон сууц, ус, цахилгаан болон бусад түлшний бүлгийн дүн 1,5 хувиар буурсан нь ерөнхий индекс 0.6 хувиар өсөхөд нөлөөлсөн байна. Тухайлбал: Өмнөх сарынхаас ямааны махны үнэ 6,3 буурч, сүүний үнэ 25 хувиар өссөн байна.



АЖ ҮЙЛДВЭР

2017 оны эхний 11 сарын байдлаар аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн 6747,2 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 24.5 хувиар буюу 1652.6 сая төгрөгөөр буурсан байна.

Нийт борлуулалтыг салбараас үзвэл уул уурхай, олборлох аж үйлдвэр 40.3, боловсруулах аж үйлдвэр 12.1, цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл 37.9 хувийг тус тус эзлэж байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн




ХӨДӨӨ АЖ АХУЙ

Баянхонгор аймаг эхний 11 сарын байдлаар оны эхний хээлтэгч малын 83.3 хувь буюу 1449.4 мянган толгой эх мал төллөсөн байна. Төллөсөн хээлтэгчийг төрлөөр нь үзвэл ингэ 7.9 мянган, гүү 32.3 мянган, үнээ 58.9 мянган, эм хонь 459.4 мянган, эм ямаа 890.9 мянган толгой тус тус төллөсөн байна.

Нийт 1449.4 мянган хээлтэгч төллөж 1431.7 мянган төл бойжуулсан байна. Бойжуулсан төлийг төрлөөр харвал ботго 7.9 мян, унага 31.7 мян, тугал 57.8 мян, хурга 455.0 мян, ишиг 879.3 мянган толгой байна.


бойжсон төл



Мөн 11 дугаар сарын 30-ны байдлаар 16.4 мянган том мал зүй бусаар хорогдсон нь оны эхний нийт малын 0.4 хувийг эзлэж байна. Хорогдлыг төрлөөр нь авч үзвэл адуу 779, үхэр 1384, тэмээ 44, хонь 4300, ямаа 9860 тус тус хорогджээ. Хорогдлын 0.4 хувь буюу 69 толгой том мал өвчнөөр хорогдсон байна.

Мөн нийт хорогдсон малын 19.0 хувь буюу 3109 толгой хээлтэгч мал хорогджээ.


том малын зүй бус хорогдол




2017 оны 11 сарын байдлаар үр тариа 13.1 тн, төмс 1547.9 тн, хүнсний ногоо 794.3 тн, тэжээлийн ургамал 464.1 тн хураан авчээ.

Аймгийн хэмжээнд нийт 15834.4 тн өвс бэлтгэсэн бол үүний 12933.1 тн өвсийг гаднаас худалдаж авсан байна. Мөн аймгийн хэмжээнд 249.3 тн гар тэжээл бэлтгэсэн байна.

Хураасан ургац



Бэлтгэсэн өвс, гар тэжээл






НИЙГМИЙН ДААТГАЛ, НИЙГМИЙН ХАЛАМЖ

Аймгийн Нийгмийн даатгалын сангаас оны эхний 11 сарын байдлаар Өндөр настны тэтгэвэрт 23084.8 сая төг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэрт 5125,2 сая төг, Тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 1621,6 сая төгрөг тус тус олгожээ.

Эдгээр тэтгэвэрүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад өндөр настны тэтгэвэр 11801,9 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр 575,6 сая төгрөгөөр өсч, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 51,3 сая төгрөгөөр буурчээ.

Нийгмийн халамжийн сангаас Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн тэтгэмжид 3812 эхэд 906,0 сая төг, Ахмад настныг асарч буй 994 иргэнд 551,5 сая төг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй 445 иргэнд 216,3 сая төг, Бүтэн өнчин хүүхэд асран хамгаалж харгалзан дэмжигч 71 хүнд 46,5 сая төг, Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжид 2035 ахмадад 406,5 сая төг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламжид 1069 иргэнд 210,4 сая төг, Нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж 1866 хүнд 1025,4 сая төг, Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжид 18 ахмадад 35,8 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Нийгмийн халамжийн сангаас олгосон тэтгэмж өмнөх оны мөн үеэс Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн тэтгэмж, Ахмад настныг асарч буй иргэнд олгох тэтгэмж, Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжууд өсч бусад тэтгэмж хөнгөлөлтүүд өмнөх оны мөн үеэс өсчээ.



ЭРҮҮЛ МЭНД


Аймгийн эрүүл мэндийн газрын мэдээгээр оны эхний 11 сарын байдлаар 1812 эх амаржиж 1811 хүүхэд төрсөн байна. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулвал амаржсан эх 0,4 хувиар, төрсөн хүүхэд 0,7 хувиар буурчээ.

Аймгийн эрүүл мэндийн салбарт нийт 241275 үзлэг хийгдэж 18046 хүн эмчлүүлсэн байна. Мөн салбарын хэмжээнд түргэн тусламжийн дуудлага ирсний 23,3 хувь буюу 3294 нь алсын дуудлага байжээ.

Эхний 11 сарын байдлаар нийт 407 хүний нас баралт бүртгэгдсэн байна. Үүнээс 1 хүртлэх насны эндэгдэл 27 бүртгэгджээ. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулвал 60,0 хувиар буурсан байна.

Мөн тайлант сарын байдлаар халдварт өвчний гаралтаар халдварт гепатит, суулгалт халдвар, салхин цэцэг өвчнүүд өмнөх оны мөн үеээс өсч, бусад халдварт өвчин буурсан байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ



ГЭМТ ХЭРЭГ

2017 оны эхний 11 сарын байдлаар 507 гэмт хэрэг бүртгэгдсэний 335 нь хөнгөн, 93 хүндэвтэр, 76 хүнд, 3 онц хүнд гэмт хэрэг байжээ. Нийт гэмт хэргийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл 50,8 хувиар өсчээ. Ингэж өсөхөд хөнгөн, хүнд хэргүүд өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Нийт гэмт хэргээс өмчийн хулгайн хэрэг 169 гарсанг задлаж харвал:

- Иргэдийн өмчийн хулгай 108
- Малын хулгай 43

- Тээврийн хэрэгслийн хулгай 18 гарсан бөгөөд эдгээр нь өмнөх оноос бүгд өссөн байна.

Гэмт хэргийн улмаас нийт 230 хүн бэртэж гэмтсэн бол 26 хүн нас барсан байна.

Нийт гэмт хэргийн улмаас 976,0 сая.төгрөгийн хохирол учирснаас 479,3 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн байна. Нийт хохирол өмнөх оны мөн үеэс 45.1 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 7,4 хувиар тус тус өсчээ.


Нийт гэмт хэрэгт 422 хүн холбогдогчоор татагдсан байна. Гэмт хэрэг үйлдэхдээ 46 холбогдогч бүлэглэж, 133 холбогдогч согтуу байсан байна.

Аймгийн цагдаагийн газрын мэдээгээр 11091 зөрчил гарсан бөгөөд 2040 шийтгэвэрээр, 9051 торгуулийн хуудсаар торгосон байна.

Эхний 11 сарын байдлаар 1403 хүн эрүүлжигдсэн бол 342 хүн баривчлагдсан байна.

Нийт гэмт хэргийн 58 хувь буюу 295 гэмт хэрэг нь аймгийн төв буюу Баянхонгор суманд гарсан байна.

Гэмт хэргийн зарим үзүүлэлт



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

2017 онд шинээр Баянлиг суманд “Тэргүүн говь” компанийн 6 гэртэй, 15 ортой, Бууцагаан суманд “Баянбүрд” компанийн 8 гэртэй, 28 ор бүхий **2** жуулчны баазууд тус тус шинээр ашиглалтад орж нийтдээ **75.800.000** сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг зарцуулсан.

Мөн Эрдэнэцогт суманд н.Энхбаатар ахлагчтай “Дөш” малчны нөхөрлөл, Шаргалжуут тосгонд н.Сэрээнжав ахлагчтай “Шаргалжуут” малчны нөхөрлөлүүд байгуулагдаж малчны хотондоо гадаад, дотоодын жуулчид хүлээж авах зорилгоор 20.000 000 төгрөгний хөрөнгө оруулалтыг өөрсдөө хийж тус бүр 2-3 гэр барьж гадаад, дотоодын жуулчдыг хүлээж авч үйлчиллээ.

1. Орлого, зарлага:

Энэ 2017 онд Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулж байгаа жуулчны бааз, амралт сувиллын газар, зочид буудал, малчны нөхөрлөл, бүлгүүдэд ирсэн судалгаагаар.

- Гадаадын **1241** жуулчин **73.300.000** орлого
- Дотоодын **28867** жуулчин **1.443.350.000** орлого
- Нийтдээ **30108** жуулчин **1.505.400.000** орлого

2. Өсөлт, бууралт:

Баянхонгор аймагт аялсан жуулчдын тоог өнгөрсөн онтой харьцуулахад дотоодын жуулчид **6 %**, гадаадын жуулчид **10,8 %**, нийт жуулчид **6,5** хувиар тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

3. Хөрөнгө оруулалт:

Аймгийн аялал жуулчлалын салбарт төрийн болон олон улсын төсөл хөтөлбөрийн зүгээс дэмжсэн санхүүжилт. Үүнд:

Төрөөс: **19.000.000 төгрөг**

Төсөл хөтөлбөрийн байгууллага: **14.000.000** төгрөгний санхүүжилт



**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**